

ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГДЭЛ

Сүхбаатар" Эрүүл мэндийн нэгдэл нь Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Сүхбаатар дүүргийн Засаг даргын бодлого чиглэл, шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт тавих, хүн амд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн 2 дахь шатны тусламж үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй төрийн үйлчилгээний байгууллага юм.

Дүүргийн эрүүл мэндийн нэгдэл нь Нийслэл хотын төв хэсэгт байрлаж поликлиник, салбар амбулатори, өрхийн эмнэлгүүд гэсэн 3 үндсэн хэсэгтэйгээр нийт 265 ажилтантай, үүнээс их эмч 111, эмнэлгийн дунд мэргэжилтэн 112, захиргаа, аж ахуй, үйлчилгээний 42 ажилтантайгаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг. Тус эрүүл мэндийн нэгдэлд "Алтан гадас" одонгоор шагнагдсан С.Дашжаргал, О.Бямбаа, Э.Үзмээ нарын шилдэг эмч нараас гадна анагаах ухааны доктор, профессор С.Манлай, төрийн соёрхолт эмч Х.Дамдин, "Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан" цол тэмдэгтэн Ё.Цолмонгэрэл, Ц.Нямжав, Д.Сарантуяа, Д.Туяа нарын 39 хүн, Ч.Ванган, Н.Лхагва, Т.Алтанцэцэг нарын "Нийслэлийн эрүүл мэндийн тэргүүний ажилтан" цол тэмдэгтэн 21 хүн, Б.Бадамханд, М.Чимгээ, Ц.Ганчимэг нарын тэргүүлэх болон ахлах зэрэгтэй эмч 31, анагаах ухааны магистр 33 хүн ажиллаж байна.



О.Бямбаа даргатай Эрүүл мэндийн нэгдлийн хамт олон



М.Чимгээдаргатай нэгдсэн эмнэлгийн хамт олон

НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

11-р хорооны нутаг дэвсгэрт байрлах тус нэгдсэн эмнэлэг нь удирдлагын үйл ажиллагааны шинэчлэлийн үр дүнд хүн амд үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг таатай орчинд жигд, чанартай, хүртээмжтэй, шуурхай үзүүлэх тогтолцоог бий болгон ажиллаж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо жил бүр өсч, эмнэлгийн нас баралт сүүлийн 5 жил дараалан буурлаа. Ажилчдын нийгмийн асуудлыг тодорхой үе шаттайгаар шийдвэрлэж байгаа бөгөөд өнгөрсөн нэг жилийн хугацаанд резидентур, тасралтгүй сургалт зэрэг сургалт семинаруудад эмч, сувилагчдыг тодорхой үе шаттайгаар хамруулан Тайландад 1, Энэтхэгт 2, Бээжинд 1 хүн сургалтанд хамрагдлаа.

Эмчилгээ үйлчилгээний чанарыг дээшлүүлж, үйлчлүүлэгчдэд тав тухтай, чирэгдэлгүй орчинг бий болгох үүднээс тусгай өрөө, чийрэгжүүлэлтийн кабинетыг шинээр тохижуулан ажиллуулж байна. Үйлчлүүлэгчдийн эмчилгээний чанарыг нэмэгдүүлэх зорилгоор эмчилгээний хоолыг Хүнс, биотехнологийн сургууль, Солонгосын хүнсний хүрээлэнтэй хамтран өвчтөн бүрийн онош, энергийн зарцуулалтанд тохирсон илчлэг, уурагтай хоолоор үйлчилж байна.